


## Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны сургамжит түүхүүд!


2019 оны 1-р сар

Сургамжит түүхүүдийг хуваалцах нь ямар нэгэн хүч нөлөөтэй бөгөөд хүний тархи, зүрх сэтгэлийг хөндөх, түүхийг өвлүүлэх үр дүнтэй арга зам болох нь зуун зууны туршид хүлээн зөвшөөрөгдсөөр ирсэн. Дэлхий даяар хүүхдүүд Ээж Галуу, Гриммийн Үлгэрүүд, Аесопын Домгууд зэрэг номын түүврээс үлгэр домогтой танилцдаг. Тэд тэрхүү үлгэр домгуудыг цээжилж, сургамж сургаалийг нь насан туршдаа санаж явдаг.

Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны үндэслэгч Тревор Клетц (1922–2013) үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой сургамжит түүхүүдийн үнэ цэнийн талаар тогтмол бичдэг байсан. Хүмүүсийн сургамжит түүхийг мартаггүй санах нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны аюул болон бусад сургалтын материалаас хамаагүй илүү найдвартай байдаг. Үйлдвэрлэлийн салбарт томоохон хэмжээний осол аваарын давтамжийг бууруулахад онцгой дэвшил гарч байгаа нь сайшаалтай.



Аесопын “Хэрээ ба Лонх”-ны домог нь бидэнд бүтээлч сэтгэлгээний үнэ цэнийг ухааруулдаг.



2017 оны 10-р сарын Веасон нь Аесопын “Чоно уйлуулсан хүү” домогт үндэслэсэн.

Өмнө нь ажилчид үйлдвэрлэлийн процесст зохистой хяналт тогтоогоогүйн улмаас юу тохиолдож болохыг өөрийн биеэр туулж байж л тухайн аюул эрсдлийн талаар айдастай болдог байсан. Өөрийн биеэр мэдрэхээс бусад нөхцөлд өдөр тутмын ажлыг хэрхэн аюулгүй гүйцэтгэх тал дээр бид сургалт, туршилт, дүрэм журамд түшиглэдэг. “Юу хийх” болон “яагаад тус ажлыг заавал тодорхой арга барил мөрдөж хийх ёстой вэ” гэдгийн хооронд сайн холбоо хамаарал байхгүй үед бид хэнэггүй буюу өөртөө хэт бардах хандлагатай болдог. Яагаад хэзээ ч тохиолддоггүй осол аваараас сэргийлж тэдгээр үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны менежментийн бүх дүрэм журмыг мөрдөх ёстой гэж? Бид шаардлагатай дүрэм журмуудыг мөрдөж байгаа учраас л осол аваар ойр ойрхон тохиолдохгүй байгаа гэдгийг мартдаг. Дүрэм журмыг нарийн чанд мөрдөхгүй байвал эрсдэлд өртөхөд хялбар болдог. Өөртөө хэт бардах болон дүрэм журам мөрдөхгүй байх нь ирээдүйн осол аваар руу хөтлөх зам дээрх эхний алхмууд юм.

## Та юу хийж чадах вэ?

- Хэрэв та үйлдвэрлэлийн салбарт ажилласан олон жилийн туршлагатай бол, өнгөрсөн хугацаанд тохиолдсон ослын үйл явдлын талаар харсан эсвэл өмнөх ажилчдаас сонссон осол зөрчилүүдийг санаж байх хэрэгтэй. Тэдгээр түүхийг туршлага багатай ажилчидтайгаа хуваалц. Тэдэнд өнгөрсөн хугацаанд “эдгээр зүйлс тохиолдсон” учраас “энд дахин тохиолдох боломжтой” гэдгийг сануул.
- Хэрэв үйлдвэрлэлийн салбарт танд харьцангуй шинэ бол ахмад ажилчдаас үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны осолтой холбоотой туршлага, мэдлэгээс нь асуу.
- Хүмүүс ажлаа солих эсвэл тэтгэвэрт гарах зэрэг шалтгаанаар хэзээ нэгэн цагт хаа нэг тийшээ явах нь зайлшгүй учир тэднийг явахаас өмнө өнгөрсөн хугацаанд тохиолдсон ослын тухай мэдээллийг нь хадгалж үлдэхийн тулд бичиж тэмдэглэх, баримтжуулах талаарх саналыг удирдлагын багтаа дэвшүүл.
- Аль ч үйлдвэрлэлийн салбарт тохиолддог ослын талаарх мэдээлэл эрж хайх, тэдгээрээс өөрийн ажилтай холбоотой сургамжийг нь тусгаж авах хэрэгтэй. Олон Веасон-оос бид хоорондоо огт хамааралгүй мэт осол авааруудын жишээнээс манай үйлдвэрлэлийн салбарт хэрэгтэй чухал сургамжуудыг авч болохыг хардаг. Тухайлбал, зорчигчдын завин дээр гарсан гал (2016 оны 9-р сар, Өөрчлөлтийн Менежмент), онгоцонд үүссэн хөдөлгүүрийн доголдол (2018 оны 10-р сар, Механикийн бүрэн бүтэн байдал, аюултай энерги), Атлантагийн онгоцны буудал дээр гарсан гал (2018 оны 12-р сар, Аврах төлөвлөгөө, түгээмэл шалтгааны алдаа) гэх мэт.

**“Сургамжит түүх гэдэг бол оюун ухаанд мартагдсан ч ой санамжид хадгалагддаг зүйл юм.”**  
**- Doctor Who, 9-р цуврал, Бүлэг 12**

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE-с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Бидэнтэй [ccps.beacon@aiiche.org](mailto:ccps.beacon@aiiche.org) эсвэл 646-495-1371 хаягаар ходбогдоно уу.